



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 17 өдөр

Дугаар А/28

Улаанбаатар хот

“Оюутан-цэрэг”-т цэргийн мэргэжил олгох
сургалтыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 198 дугаар захирамж, Засгийн газрын 2017 оны 32 дугаар тогтоолоор батлагдсан “Оюутан-цэрэг”-т цэргийн мэргэжил олгох сургалтын журам, Засгийн газрын 2014 оны 40 дүгээр тогтоол, Батлан хамгаалахын сайдын 2018 оны А/376 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Оюутан цэрэг”-т цэргийн мэргэжил олгох сургалтыг 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн зохион байгуулахыг Цэргийн штаб /хурандаа Ж.Болдбаатар/-т даалгасугай.

2. Нийслэлийн хэмжээнд “Оюутан цэрэг”-т цэргийн мэргэжил олгох сургалтыг зохион байгуулах ажлын хэсгийг 1 дүгээр, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

3. “Оюутан цэрэг”-т цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагдах оюутан суралцагчдыг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах ажлыг дүүргийн эрүүл мэндийн төвүүд дээр зохион байгуулж, албан хэрэг хөтлөлтийн стандартын шаардлага хангасан маягт хэвлүүлэх, ажиллах байр, тээврийн хэрэгслээр хангахад шаардагдах зардлыг өөрийн батлагдсан холбогдох зардлаас гаргаж санхүүжүүлэхийг дүүргүүдийн Засаг дарга нарт даалгасугай.

4. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж, 2019 оны 3 дугаар улиралд багтаан дүнг танилцуулахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб /хурандаа Ж.Болдбаатар/-т үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
НОГООН ХӨГЖИЛ, АГААРЫН
БОХИРДЛЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН
ОРЛОГЧ

Ж.БАТБАЯСГАЛАН

111020000096

Нийслэлийн Засаг даргын 2019 оны
...сарын 12-ны өдрийн
...захирамжийн 1 дүгээр
хавсралт

**“ОЮУТАН-ЦЭРЭГ”-Т ЦЭРГИЙН МЭРГЭЖИЛ
ОЛГОХ СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ХЭСЭГ**

Ажлын хэсгийн
ахлагч:

-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын
Цэргийн штабын дарга, хурандаа Ж.Болдбаатар

Гишүүд:

-Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого
төлөвлөлтийн газрын орон нутгийн хамгаалалт,
Улсын дайчилгааны хэлтсийн ахлах мэргэжилтэн
Дэд хурандаа С.Рагчаадорж /зөвшилцсөнөөр/;

-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл
мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн дарга
Э.Дагиймаа;

-Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын
дарга Д.Дэлгэрмаа;

-Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын
дарга Б.Амартүвшин;

-Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын
дарга Н.Энхболд;

-Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын
газрын дарга Д.Төмөрбаатар;

-Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын
дарга Б.Энхболд;

-Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын
дарга А.Дамцагдорж.

Нарийн бичгийн
дарга:

-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн
штабын тоо бүртгэлийн офицер, дэд хурандаа
С.Баярмагнай.

Нийслэлийн Засаг даргын 2019 оны
 01 дугаар сарын 17-ны өдрийн
 захирамжийн 2 дугаар
 хавсралт

**"ОЮУТАН-ЦЭРЭГ"-Т ЦЭРГИЙН МЭРГЭЖИЛ ОЛГОХ
 СУРГАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
 ТӨЛӨВЛӨГӨӨ**

д/д	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах хүн
1.	"Оюутан-цэрэг"-т цэргийн мэргэжил олгох сургалтыг сурталчлах ажлыг зохион байгуулах	2 дугаар сарын 22-26-ны өдөр	Дүүргүүдийн ЗДТГ-ын цэргийн штаб
2.	Магадлан итгэмжлэгдсэн их дээд сургуульд суралцаж байгаа 18 нас хүрсэн 1 дүгээр дамжааны оюутан суралцагчдын судалгааг гаргах	2 дугаар сард	Дүүргүүдийн ЗДТГ-ын Цэргийн штаб
3.	"Оюутан-цэрэг"-т цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагдах оюутан суралцагчдыг бүртгэх	2 дугаар сарын 25-нээс 03 дугаар сарын 07-ны өдрүүдэд	Дүүргүүдийн ЗДТГ-ын Цэргийн штаб
4.	"Оюутан-цэрэг"-т цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагдах оюутан суралцагчдыг эрүүл мэндийн үзлэгт оруулах	3 дугаар сарын 21-22-ны өдрүүдэд	Цэргийн төв эмнэлэг, ҮБХИС, Дүүргүүдийн ЗДТГ-ын Цэргийн штаб
5.	"Оюутан-цэрэг"-т цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагдах оюутан суралцагчдаас бие бялдрын хөгжлийн шалгалт авах	3 дугаар сарын 23, 24-ний өдрүүдэд	ҮБХИС, Дүүргүүдийн ЗДТГ-ын Цэргийн штаб
6.	Оюутан-цэрэг"-т цэргийн мэргэжил олгох сургалтын сонгон шалгаруулалтад тэнцсэн оюутнуудын нэрийн жагсаалтыг Батлан хамгаалах яаманд өгөх	3 дугаар сарын 27	Тоо бүртгэлийн офицер дэд хурандаа С.Баярмагнай
7.	Сонгон шалгаруулалтад тэнцсэн оюутнуудад "Цэргийн ерөнхий бэлтгэл" хичээлийн сургалтыг зохион байгуулах	4-6 дугаар сард	ҮБХИС
8.	Сонгон шалгаруулалтад тэнцсэн оюутнуудад "Цэргийн мэргэжлийн бэлтгэл" хичээлийн сургалтыг зохион байгуулах	6-8 дугаар сард	ҮБХИС
9.	"Оюутан-цэрэг"-т цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагдсан оюутан, суралцагчдыг хүлээн авах	8 дугаар сард	Дүүргүүдийн ЗДТГ-ын Цэргийн штаб
10	"Оюутан-цэрэг"-т цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагдсан оюутан, суралцагчдын материалыг харьяа аймаг, дүүргүүдийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабт хүргүүлэх	8 дугаар сард	Тоо бүртгэлийн офицер дэд хурандаа С.Баярмагнай